

Би бурхны шашных биш, католик шашных ч биш. Би Үнэн ёсонд хамаарагдаж, Үнэн ёсыг уламжлан бадруулна. Та бурхны шашинтан, католик шашинтан, бомбын суртахууныхан гэх буюу аль дуртай дуудлагаараа яаж дуудсан ч бүр болно, би бүхнийг баярлан угтана.

—Suma Ching Hai—

Бид дотооддоо бүхий амгалан тайван байдлаа олмогц өөр ямар ч юмыг цөм олж чадна. Бид гагцхүү дотооддоо бүхий диваажин — дотоод дахь мөнхийн билгээ нээгдүүлэн зохицуулах ба төгс чадварт хүчээ эрж олох үед, энэ дэлхийн хүсэл эрмэлзлэл буюу диваажны хүслэнг биелүүлж чадна. Учир нь эдгээр бүхэн цөм диваажингаас үүсэлтэй юм. Бид эдгээрийг олохгүй бол бидний эрх сүр, эд

баялаг, зэрэг хэргэм ямар ч байлаа гээд бидний хүсэл эрмэлзлэл үүрд биелэгдэж чадахгүй юм.

—Suma Ching Hai—

Манай номын ёс бол, та энэ ертөнц дээр юу хийх шаардлагатай бол түүнийгээ бүх сэтгэл, байдаг зоригоороо хийхийн хамт өдөр бүр сэм завилна. Сэм завилмаанжин нэн илүү мэдлэг, нэн арвин билэг ухаан, нэн сайхан амгалан тайван байдлыг олж, өөрийн бие болон дэлхий дахинд үйлчилж чадна. Өөрийн дотоод дахь сайн сайхан зан чанараа мартаж болохгүй, өөрийнхөө дотоодод оршиж байгаа хаан хурмастыг мартаж болохгүй, сэтгэлд байгаа бурхнаа мартаж болохгүй.

—Suma Ching Hai—

## УДИРТГАЛ

Этр урьд цагаас нааш, аль нэгэн цаг  
Үед ч гэсэн хэдэн зүйрлэшүй гайхамшигт  
хүн илрэн гарч байсан. Тэд ертөнцөц  
ирснийх нь цорын ганц зорилго нь хүн  
төрөлхтний оюун сэрэлтийг  
дээшилүүлэхэд буй. Есүс – Христ нь  
эдгээрийн нэг нь юм. Шагзамунь бурхан  
болон Мухаммед бас ч ийм билээ. Энэхүү  
эрхэм хоёулыг хүмүүс хэдийний сонсож  
мэдээд сайтар ойлгосон. Гэтэл бас өөр  
нэлээд хүмүүс алдраа хараахан  
үлдээсэнгүй. Зарим нь шавь элсэж байсан  
болохоор зарим хүмүүст танигдсан,  
бусад нь дуу аниргүй дугуй суужээ.  
Эдгээр хүмүүс нь адил бус цаг үе, төр  
пүрэнд шалтгаалагдаж, адил бусын  
нэртэй байсан. Хүмүүс тэднийг багш,

сахиусны хувилгаан бие, билэг нээгсэд, ертөнцийг аврагч, Масайя, Мария, хаан хурмастын элч, гҮрҮ, эдүүгээх богд... гэх мэтээр дуудаж байсан. Тэд ирснээс билэг нээх, авран гаргах, сэхээрүүлэх, туулан тонилгох буюу ухамсралт гэдгээ бидэнд олгожээ. Дээр хэрэглэсэн Үгс нь хэдийгээр адил бус боловч уг чанар нь эгээ адил хамтын дархан эх сурвалжтай, өндөр ёс моральтай, ертөнцийн хүмүүсийг өөд татах ид чадлыг адилаар буй болгосон, яг л өнгөрсний богд шиг. Тэд хэдийгээр бидэнтэй хамт оршиж байвч бид тэднийг дэмий л анхаардаггүй билээ. Suma Chins Hai бол тэдний доторхи нэг нь юм.

Чинхай багш олонхи хүний таньдаг эдүүгээх богдчуудтай адилгүй. Тэр бол бүсгүй хүн. Нэлээд олон бурхны сургаалтад жич бусад хүнүүс эмэгтэй

хүн бурхан болж чадахгүй гэдэг чалчааг үнэмшсэн. Тэр бол Азийн хүн. Өрнө дахины олонхи хүмүүс тэдний ертөнцийн аврагчаа тэдэнтэй адил төсөөтэй харагдах болоодой гэж хүсэж эрмэлздэг. Гэтэл манай энэ дэлхийн олон газрын адил бус шашин суртахууны орчин ахуйгаас ирэгсэд, манай багштай танилцаж, түүний номын ёсыг хөөцөлдөөд, багш чухам ямар хүн гэдгийг тодорхой ойлгосон. Түүнтэй танилцъя гэвэл та уужим сэтгэл, нэгэн зоригоор хичээнгүйлэн сүсэглэх хэрэгтэй. Бүх хүчээ зориулан, ганц сэтгэлийг баривал болчихно! Ондoo юу ч хэрэггүй.

Хүмүүс олонхи цагаа аж төрж амьдралын хэрэгцээгээ хангахад зарцуулж байна. Бидний ажиллаж байх нь өөрийнхөө энхрийлж хайрладаг хүнээ аль болохоор тааламжтай амьдруулахын төлөө

юм. Сэлүү цагт манай анхаарал улс төр, нийгмийн ажиллагаа, зурагт радио, зурагт сонин Үзэх зэрэг явдалд хуваагдан татагддаг.

Гэтэл аль нэгэн өдөр дотоод дахь ахуй ойлголт нь хаан хурмасттай шууд нэвтрэлцээд, түүний аугаа хайрыг хүртэж эдэлбэл, аж амьдрал гэдэг чинь нйм л биш гэснийг мэдэж болно.

Энэхүү сайхан мэдээг нэн өргөн дэлгэрэнгүйгээр хүмүүст мэдээлж чадахгүй нь маш харамсалтай гэж бид бодно. Учир нь амьдралын дундах буй бүхий сэжигтэй асуудал, гаслан зовлон, зэргийн хариулт нь хэдийний бүр бидний дотоодод оршиж аль үед илрүүлэхийг сэм хүлээж байна. Гар сунгамагц диваажны ордыг олж болно гэснийг бид хэдийн мэдсэн. Хэрэв бидний чин үнэнч халуун дотно сэтгэлгээс болж, Үг ярианы талаар

таны оюун ухааныг халдаж хөндсөн газар байвал уучлахыг хүснэ. Учир нь бид өөрийн үзсэнээ, мэдсэнээ дугуй сууж дуугүй хадгалахад хүчиртэй юм.

Бид Suma Chins Hai – н шавь, Арьвалын номын цогцсын хамт бясалгагчдын хувиар энэхүү Үлгэр дэвтрийг хэвлүүлэв. Манай багшийн удирдлагын доор, танд тусалж номын баясал бялхсан хүслэнт ахуйг биечлэн ойлгуулахыг хүссэн юм.

Бид сэм завилал хийж, нам гүмээр дотогшоо харж, залбиран даатгахын чухлыг Чинхай багш сурган зааварлажээ. Бид энэ насаа Үнэнхүү баяр цэнгэлтэй өнгөрүүлэе гэвэл бид өөрийнхөө " дотоодын хаан хурмаст" (бурхан чанар)–аа илрүүлэн олох чухалтай гэж багш тодорхой зааварлажээ. Билэг нээгдэх нь тийм л нууц далд бөгөөд олж чадахгүй

онцгой хол юм биш, эсхүүл олноос хөндийрөн зайлсан тэдгээр хүнүүс л олж чаддаг юм биш гэж өгүүлжээ. Түүний ажил нь манай дотоод дахь " хаан хуамаст" (бурхан чанар) – ыг дуудан сэргээхийн хамт, өөрөө бас энгийн маягаар амьдардаг. Тэр өгүүлсэн нь: " Үнэн ёсыг бид цөм мэдэж байсан, гэтэл одоо бид мартчихжээ. Иймээс заримдаа бид бас хүний амьдралын зорилтод анхаарлаа тавьж, юуны учир Үнэн ёсыг эрж олох, юунд сэм завилал хийх ба юунд хаан хурмаст, бурхныг итгэх гэдгийг ойлгох хэрэгтэй. Орчлонгийн хамаг дээд хүчнийг төлөөлөх хүнийг итгэх чухалтай" гэжээ. Тэр биднийг өөрийгөө дагатугай гэж шаардаагүй, зөвхөн өөрийнхөө билэг нээгдсэн явдлаар жишээ болгож, бусад хүмүүсийг Үнэнхүү туулуулан тонилгох гэж байгаа юм.

Энэ товхимолд Suma Ching Hai – н сургаалын ёсны тухай танилцуулсан юм. Энэ товхимол дахь ном тайлал, шүүмж, жишээнүүд нь цөм Чинхай багшийн ном тайлахыг сонсоод тэмдэглэн эмхэлсэн зүйлүүд болно. Заримыг нь бусад хэлнээс орчуулан найруулж авчээ. Тухайн газарт нь ирж дууны кассет, дүрсний кассетыг сонсох буюу үзтүгэй гэж бид сануулъя. Ингэвэл та энэхүү материал буюу номоос нэн илүү сайн сайхан ойлголтыг олж болно. Хэлэлгээнгүй түүний өөрийн биетэй нь уулзвал нэн гоё сайхан ойлголттой болох болно.

Зарим хүнд авч хэлбэл Чинхай багш бол дар эх, зарим хүнд авч хэлбэл бас эцэг нь болно. зарим хүн түүнийг янаг хайрт гэж үздэг. Хамаг адагтаа тэр хүртээн туслахын төлөө энэ ертөнц дээр

ирснээс биш ямар нэгэн юм олж авахаар ирсэн бус. Заавар, зөвлөгөө өгөх ба сэтгэлийн ашиг хүртээхдээ ямар ч төлбөр авдаггүй билээ. Түүний цорын ганц олох зүйл гэвэл та нарын гаслан зовлон, уйтгар гуниг болно, хэрэв та дуртай бол.